



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 596

Улаанбаатар хот

“Төв АЗЗА” төрийн өмчит
хувьцаат компанийн 2020 оны эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,
хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төв АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2020 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Д.Болдбаатарт даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

00011




Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 1-ны өдрийн
596 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ТӨВ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2020 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Х/н	2018 оны гүйцэтгэл	2019 оны		2020 оны төлөвлөгөө	Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл		2020 төл/2019 ХБГ	2020 төл- 2019 ХБГ
1	Нийт орлого	мян.төг	2,787,143.6	1,239,964.8	1,825,092.6	1,831,988.8	100.4	6,896.1
2	Улсын чанартай авто зам засвар арчлалтын ажил	мян.төг	751,462.4	625,716.4	1,440,836.3	935,170.6	64.9	(505,665.7)
3	Орон нутгийн чанартай авто зам засвар арчлалтын ажил	мян.төг	2,035,681.2	614,248.4	384,256.3	896,818.2	233.4	512,561.9
4	Нийт зардал	мян.төг	2,780,705.0	1,236,312.3	1,701,374.2	1,823,628.2	107.2	122,254.0
5	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	148,278.4	190,812.4	158,931.5	246,480.7	155.1	87,549.2
6	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	6,438.6	3,652.5	123,718.4	8,360.6	6.8	(115,357.9)
7	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	5,794.8	3,296.8	111,346.6	7,524.6	6.8	(103,822.1)
8	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	203,447.0	129,651.6	77,720.9	379,198.1	487.9	301,477.2
9	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	285.5	3,880.8	869.2	1,254.1	-	384.9
10	Нийт ажиллагсдын тоо	хүн	38	44	28	44	157.1	16.0
11	Нийт цалингийн сан	мян.төг	310,818.7	343,350.0	277,564.2	580,449.2	209.1	302,884.9
12	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	681.6	650.3	826.1	1,099.3	133.1	273.3
13	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.00	0.99	0.93	0.99	106.2	0.1
14	Хөрөнгө оруулалт	мян.төг	3,290.0	63,000.0	32,200.6	105,099.3	326.4	72,898.7
15	Нийт авлага	мян.төг	106,805.8	66,234.3	335,572.3	536,434.1	159.9	200,861.8
16	Нийт өглөг	мян.төг	231,843.0	384,807.4	351,256.4	304,807.4	86.8	(46,449.0)
17	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	231,843.0	384,807.4	351,256.4	304,807.4	86.8	(46,449.0)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн
596...дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



"ТӨВ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (мян.төг)	Нийт үнэ (мян.төг)
1	Асфальтоны индүү	ш	1	60,000.0	60,000.0
2	Пүү	ш	1	6,000.0	6,000.0
3	Компьютер	ш	7	1,919.9	13,439.3
4	Ширээ, сандал	ком	1	1,700.0	1,700.0
5	Асфальто зүсэгч хөрөө	ш	1	3,960.0	3,960.0
6	Вагон сууц	ш	2	9,000.0	18,000.0
7	Гар кудирнатор	ш	1	2,000.0	2,000.0
	Нийт үнэ				105,099.3 (нэг зуун таван сая ерэн есөн мянган гучин төгрөг)